



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Сарын аян зохион байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны ажиллах журмын 2.1, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян"-ыг зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2. Удирдамжийн дагуу аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнгийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд ирүүлэхийг Уул, уурхай, хүнд үйлдвэрийн салбарын нийт аж ахуйн нэгж, ажил олгогчдод үүрэг болгосугай.

3. Сарын аяны хүрээнд салбарын хэмжээнд аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаарх тайлан, мэдээг нэгтгэн салбар хорооны хурлаар хэлэлцүүлэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг салбар хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

08 0327

Төрийн нарийн бичгийн даргын  
2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн  
А/... дугаар тушаалын хавсралт

**Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын  
“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг  
зохион байгуулах ажлын удирдамж**

**Нэг. Зорилго:**

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт, салбарт ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршино.

**Хоёр. Хамрах хүрээ**

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгжүүд, ажил олгогчид, ажилтан ажиллагсад.

**Гурав. Хугацаа:**

Сарын аян 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд үргэлжилнэ.

**Дөрөв. Аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

1. Ажил олгогч, аж ахуйн нэгжүүд нь сарын аяны хүрээнд аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлж, дүгнэх.
3. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг фото зураг, видео бичлэг, бусад хэлбэрээр баталгаажуулах, идэвхи, санаачлага, үр дүнтэй ажилласан бүтэц, нэгж, ажилтныг үнэлэх, урамшуулах ажлыг зохион байгуулах.
4. Үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны ХАБЭА-н салбар хороонд ирүүлэх.

**Тав. Аяны хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцох.**

1. Аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаарх тайлан, мэдээг салбар хорооны хурлаар хэлэлцэн дүгнэх.
2. Тайлан, мэдээг нэгтгэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх.
3. Сайн санаачлага, үр дүнтэй ажилласан байгууллага, аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх.